

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

УС ЗҮЙН ТООЦООНЫ АЖЛЫН ДААЛГАВАР:

1. **Захиалагч:** Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
2. **Гүйцэтгэгч:** Мэргэжлийн байгууллага
3. **Ажлын төрөл:** Монгол -Орос – Хятадын эдийн засгийн коридорын Төмөр замын төв шугамын Сүхбаатар -Замын Үүд хэсэглэлийг шинэчлэн хөгжүүлэх Техник эдийн засгийн үндэслэлд зориулсан төмөр замын үерийн ус өнгөрүүлэх байгууламжуудын гидравлик тооцоо, ус хуралдах талбай, сайруудын ус зүйн тооцоо
4. **Ажил гүйцэтгэх хугацаа:** Гэрээнд заасан хугацааны дагуу ажлын 30 хоногт багтаан гүйцэтгэнэ.
5. **Тооцоо хийгдэх газар:** Баруун хараа -Аршаант 152км, Оорцог энгэр - Чойр 10км, Чойр -Айраг 38км, Сайншанд -Шаргын овоо 241км **нийт 461км**
6. **Санхүүжилтийн эх үүсвэр:** Улаанбаатар төмөр замын санхүүжилтээр
7. **Ажлын зорилго:** УБТЗ -ын төв шугамыг шинэчлэн хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэлийн төмөр замын трассын дагуу үерийн ус өнгөрөөх байгууламжуудын гидравлик үзүүлэлтийг шинэчлэн тооцох, тус тооцоо судалгаан дээр үндэслэн төмөр замын дагуу өргөтгөх болон шинээр барих гүүр, хоолойн хэмжээг тодорхойлох, бусад арга хэмжээний төлөвлөлтийг гаргах.
8. **Агуулга:**
 - 8.1. Судалгааны аргачлал
 - 8.2. Судалгаа хийгдэж буй газрын товч танилцуулга (объектийн байршил, уул зүйн нөхцөл, хөрс, ургамлын нөхцөл, ус зүйн нөхцөл, уур амьсгалын нөхцөл)
 - 8.3. Судалгааны тайлан, (ус зүйн судалгаа, хөрс, ургамлын бүрхэвчийн судалгаа, инженер гидротехникийн судалгаа)
 - 8.4. Дүгнэлт
9. **Судалгааны ажилд шаардлагатай захиалагчаас өгөх үндсэн мэдээлэл (Гүйцэтгэгчийн хүсэлтээр нэмж оруулах боломжтой)**
 - 9.1. Хиймэл төхөөрөмжүүдийн төрөл;
 - 9.2. Хиймэл төхөөрөмжүүдийн схем;
 - 9.3. Хиймэл төхөөрөмжийн байршил (уртраг, өргөргөөр);
 - 9.4. Судалгаа хийгдэж хиймэл төхөөрөмжүүдийн өмнөх ус зүйн тооцоо;
10. **Судалгаанд тавигдах шаардлага:**
 - 10.1. Хайгуул судалгааны үндсээр үерийн урсцыг $Q_{0.33\%}$, $Q_{1\%}$ -ийн магадлалтайгаар тодорхойлох
 - 10.2. Хоногийн хамгийн их хур тунадас түүний хангамшилыг цаг уурын станцуудын олон жилийн ажиглалтыг үндэслэн гаргах
 - 10.3. Ус хураах талбай болон хөрсний байр зүйн зургийг цаас болон электрон хэлбэрээр хүлээлгэж өгөх
 - 10.4. Ус хураах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсцын тооцоог /БНБД 2.01.14-86. УБ 1986/ ус зүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрмийг ашиглах
 - 10.5. Судалгааны тайланг 2 хувь үйлдэж УБТЗ ХНН Төсөл хэрэгжүүлэх нэгжид актаар хүлээлгэн өгнө.
 - 10.6. Судалгааны дүгнэлт хэсэгт өмнө нь хийж байсан ус зүйн тооцоотой харьцуулсан дүгнэлт гаргах.